



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/20

Дархан

“Онцгой тохиолдолд ажиллах журам”
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 3 дугаар хавсралт, Иргэний нисэхийн 174 дүрмийн 73 дахь хэсэг, Нислэгийн цаг уурын төвийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй иргэний агаарын тээврийн нислэгт үйлчлэх Онцгой тохиолдолд ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Урьдчилан мэдээлэхийн салбарын инженерүүдэд үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга (Х.Мэнджаргал)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны Нислэгийн цаг уурын үйл ажиллагааны зааврын Б бүлгийн 7.2.1, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс мөрдөгдөж байсан Үйл ажиллагааны зааврын 2 дугаар хавсралтын осол зөрчлийг мэдэгдэх хуудсыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА




С.АЛТАНДОЛГИОН



БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

Энэхүү хуудас нь "Онцгой тохиолдолд ажиллах журам"-ын хамт хүчин төгөлдөр байна.

Боловсруулсан 1	Хянасан 2	Баталсан 3
Албан тушаал: Урьдчилан мэдээлэхийн технологич инженер	Албан тушаал: Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Албан тушаал: Төвийн дарга
Нэр: А.Батгэрэл	Нэр: Х.Мэнджаргал	Нэр: С.Алтандолгон
Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг: 
Огноо:	Огноо:	Огноо: 



АГУУЛГА

1. Баталгаажуулалтын хуудас	1
2. Өөрчлөлтүүдийн бүртгэл	3
3. Баримт бичгийн хяналтын мэдээлэл	4
4. Товчилсон үгийн тайлбар	5
5. Онцгой тохиолдолд ажиллах журам	6-9
6. Хавсралт 01 Байгууламжийн доголдлын зөрчлийг мэдээлэх хуудас	10
7. Хавсралт 02 Түгээгдсэн мэдээллийн зөрчлийг мэдээлэх хуудас	11
8. Хавсралт 03 Онцгой тохиолдолд мэдээлэл дамжуулах ерөнхий бүдүүвч	12

ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН БҮРТГЭЛ

1. “Онцгой тохиолдолд ажиллах журам”-д нэмэлт, өөрчлөлтийг уг журмыг хянасан албан тушаалтан хянан баталгаажуулна.
2. Шаардлагатай бол журмыг баталгаажуулсан албан тушаалтанд танилцуулж, зөвшөөрөл авсан байна.
3. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажилтан доорх хүснэгтийг заавал бөглөсөн байх шаардлагатай.

№	Өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Тайлбар	Гарын үсэг
1	2	3	4	5
1	Хэвлэл 1	2024.11.18	Төвийн даргын 2024 оны 120 дугаартай тушаалаар батлагдсан анхны хэвлэл	А.Батгэрэл



БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн дэлгэрэнгүй Document Details		
1	2	3
1	Баримт бичгийн нэр Document Name	Онцгой тохиолдолд ажиллах журам
2	Баримт бичгийн зорилго Purpose of the Document	Нислэгийн цаг агаарын мэдээ мэдээллийн хангалтын ажлын тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа, нислэгийн үйл ажиллагаанд учирсан гэнэтийн осол, саатал, эвдрэл, сүйрэл, нислэгийн цаг агаарын мэдээнээс шалтгаалсан саатал, зөрчлийн талаар мэдээлэх чиг үүргийг шат дараалан шуурхай арга хэмжээ авч зохицуулахад оршино.
3	Баримт бичгийн код Unit identification	-
4	Хуудасны тоо Total page	12
5	Хэлбэр Document Status	Хэвлэмэл А-4
6	Хадгалалт Archive	Мэдээллийн дэд сангийн технологич инженерийн цахим архивын санд хадгална.
7	Хариуцах албан тушаалтан Document Owner	Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга
8	Батлагдсан огноо Date approved	2024.11.18
9	Батлагдсан байгууллага, албан тушаалтан Approved by	Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн дарга
10	Өөрчлөлт орсон огноо Amendments	-
11	Баримт бичгийн бүтэц Document Structure	4 бүлэг
12	Хавсралт Attachment	3

Тараагдсан байдал Distribution				
1	2	3	4	5
№	Хэлтэс, алба Division name	Хяналтын дугаар	Хувь Version	Гарын үсэг Signature
1	УЦУОШТ-ийн архив	01	1	
2	Нислэгийн цаг уурын төв /Aviation Weather Center/	03	1	
3	Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс /Department of Meteorology and Information Services/	04	2	
	Нийт		4	

Хэвлэлийн дугаар: 01
Өөрчлөлтийн дугаар: 00
Огноо: 2024.11.18



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЦУМУХ	-Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтэс
НЦУТ	-Нислэгийн цаг уурын төв
НААХЗА	-Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба
ОУНБ	-Олон улсын нисэх буудал
УЦУОШТ	-Ус цаг уур, орчны шинжилгээний төв
ЦУОШГ	-Цаг уур, орчны шинжилгээний газар
ЗСААХ	-Захиргаа санхүү, аж ахуйн хэлтэс
MDS	- Мэдээллийн дэд сангийн систем
ХАБЭА	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ТОИМ ТАҒ	- Урьдчилсан мэдээ, тойм
AMD	- Нарийвчилч өгөх мэдээний бүлэг
НИ-5	- Чиглэлийн урьдчилсан мэдээ



ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нислэгийн цаг агаарын мэдээ мэдээллийн хангалтын ажлын тасралтгүй хэвийн байдал, нислэгийн явцад учирсан гэнэтийн осол, байгууламжийн доголдол, нислэгийн цаг агаарын мэдээнээс шалтгаалсан зөрчлийн талаар мэдээллийг шуурхай мэдэгдэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Төвийн орон тоо, бүтцэд өөрчлөлт орсон, дээд шатны байгууллагын тушаал, шийдвэр, мөн хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжөөр өгөгдсөн шаардлагын дагуу Онцгой тохиолдолд ажиллах журамд /цаашид журам гэх/ өөрчлөлт оруулна.

1.3 Журамд оруулсан өөрчлөлтийг "Өөрчлөлтүүдийн бүртгэл" хүснэгтэд бөглөж холбогдох албан тушаалтанд танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Хоёр. Онцгой нөхцөл, онцгой тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Нийтийг хамарсан цар тахал, гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, үер ус гэх мэт байгалийн давагдашгүй хүчин зүйлийг Онцгой нөхцөл гэх бөгөөд тухайн үеийн нөхцөл байдалд тусгай чиг үүргийн дагуу ажиллана.

2.2. Нислэгийн саатал, осол, зөрчил гарсан буюу гарах урьдчилсан нөхцөл бүрдсэн эсвэл нислэгийг цаг агаарын мэдээллээр хангах хэвийн ажиллагаа алдагдсан буюу алдагдах урьдчилсан нөхцөл бүрдэх, буудал орчим буюу нислэгийн замд нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл ажиглагдсанаас шалтгаалж нислэгийн тогтмолжилт алдагдах, сүлжээ, тоног төхөөрөмж гэмтсэн, цахилгаан эрчим хүч тасрах зэргээс нислэгийн цаг агаарын мэдээний хангалтын ажил саатах, зогсох, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарах, албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд аюултай байдал буй болж ажилтан ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй болох зэргийг онцгой тохиолдол гэнэ.

2.2.1. Нислэгийн саатал, зөрчил (осол) гарсан буюу гарах урьдчилсан нөхцөл бүрдсэн, нислэгийн цаг агаарын мэдээллээр хангах хэвийн ажиллагаа алдагдсан буюу алдагдах урьдчилсан нөхцөл бүрдсэн үед:

- a) УЦУОШТ-ийн ЦУМҮХ-ийн Урьдчилсан мэдээ мэдээллээр хангах хэсгийн тоног төхөөрөмжүүд, холбоо сүлжээний ажиллагаа, хэвийн байгаа эсэхийг тус тус шалгах;
- b) УЦУОШТ-өөс цаг агаарын мэдээгээр хангагдсан онгоц нь саатсан, нислэгийн зөрчил (осол) гарсан үед ээлжийн Урьдчилан мэдээлэхийн инженер мэдээллийг нарийвчлан, боломжтой бүх мэдээллийг цуглуулан Төвийн дарга, хэлтсийн дарга, урьдчилан мэдээлэхийн технологич инженер нарт мэдэгдэх бөгөөд ажлын бус цагаар дээрх мэдээлэл авсан даруйд ажлын байранд яаралтай ирэх;

- с) ЦУМУХ-ийн дарга нислэгийн зөрчил (осол)-тэй холбогдох бичиг баримтуудыг бүрэн эхээр нь авч НЦУТ-ийн Аюулгүй байдал, чанарын менежерт хүлээлгэн өгөх;
 - д) Нислэгийн зөрчил (осол)-ийн тухай мэдээллийг төвийн дарга НЦУТ, ЦУОШГ-ын дарга нарт тус тус мэдэгдэх;
 - е) Энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу байгууламжийн доголдлын зөрчлийн мэдээлэх хуудсанд бүртгэл хөтөлж, төвийн даргын зөвшөөрөлгүйгээр мэдээлэл гаргахыг хориглоно;
- 2.3. Нислэгийн замд нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл (дуу цахилгаан, мөндөр, мөстөлт, хүчтэй сэгсрэлт, үүл ба хур тунадсанд дунд зэргийн болон хүчтэй мөстөлт, зайрмагтсан хур тунадас, догшин хуй, нам өндрийн салхины хүчтэй шилжлэг, цаг агаарын үзэгдэл, элемент нислэгийн замд хязгаарлалтаас давж тогтвортой муудах) ажиглагдсанаас нислэгийн тогтмолжилт алдагдах үед:
- 2.3.1. Хэрэв урьдчилсан мэдээнд (ТОИМ TAF) тусгагдсан бол бодит байдлыг ээлжийн Урьдчилан мэдээлэхийн инженер нь НЦУТ-д (71287279, 71287419), нислэгийн удирдагч (99060925, 94920008)-т утсаар;
 - 2.3.2. Хэрэв дээрх үзэгдэл урьдчилсан мэдээнд (ТОИМ TAF) тусгагдаагүй бол уг үзэгдлийн эрч хүч, эхлэх, төгсөх хугацааг тооцож, урьдчилсан мэдээг нарийвчлах (ТОИМ TAF AMD) болон угталтын мэдээ бичиж нислэгийн удирдагч (99060925, 94920008), НЦУТ-д (71283039, 71283215) шуурхай мэдээ дамжуулна. Шаардлагатай тохиолдолд холбогдох зураг мэдээг MDS мэдээллийн системд байршуулсан тухай нислэгийн удирдагчид шуурхай дамжуулж, мэдээг дамжуулсан хугацаа, мэдээ хүлээн авсан хүний нэр, албан тушаалыг зөвлөгөө өгөх дэвтэрт тодорхой бичиж тэмдэглэнэ.
 - 2.3.3. 3.3 дах заалтын Нислэгийн замын цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдсан үед уг үзэгдлийн байрлал, шилжилт, хурд, эрч хүчний өөрчлөлтийг тодорхой заасан урьдчилсан мэдээг (ТОИМ TAF), чиглэлийн урьдчилсан мэдээ (НИ-5) мэдээг бичиж, MDS-д шуурхай дамжуулж, нислэгийн удирдагчид танилцуулсан цагийг тодорхой бичнэ.
- 2.4. Интернет сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа доголдсоноос Нислэгийн цаг агаарын мэдээний хангалтын ажил саатсан, зогссон үед:
- 2.4.1. Интернет сүлжээ, тоног төхөөрөмж, цаг уурын станц (AWS-310) гэмтсэн, эсвэл хэвийн ажиллагаа нь доголдсон үед ээлжийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер, холбогдох хэлтсийн дарга, холбоо сүлжээ хариуцсан технологийн инженер нарт яаралтай мэдэгдэж засуулах арга хэмжээ авна.
 - 2.4.2. Холбоо сүлжээ хариуцсан технологич инженер нь интернет сүлжээ, тоног төхөөрөмжийн доголдолыг арилгасны дараа эвдрэл, гэмтэл гарсан шалтгаан нөхцлийн талаар хувийн хэрэгт нь тодорхой тэмдэглэл хөтөлж, хэлтсийн даргад танилцуулна.



- 2.4.3. Цахилгаан тасарсан үед ээлжийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ (72004000), ЦУМУХ-ийн даргад яаралтай мэдэгдэж цахилгаан үүсгэр /мотор/-ийг яаралтай залгаж хэвийн ажиллагааг хангах арга хэмжээ авна.
 - 2.4.4. Интернэтийн сүлжээ ажиллагаагүй болсоноос нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах боломжгүй болсон тухай НЦУТ-ийн Аюулгүй байдал чанарын менежерт мэдэгдэж орлон ажиллах журмын дагуу ажиллах тухай албан бичгийг хүргүүлнэ.
 - 2.4.5. Холбоо сүлжээнээс шалтгаалж нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах боломжгүй болсон тухайгаа НЦУТ-ийн Аюулгүй байдал чанарын менежерт мэдэгдэнэ.
- 2.5. Объектын гал түймэр гарсан үед:
- 2.5.1. Ажлын байранд гал гарвал ОБГ-ын шуурхай дуудлагын (7037101) утас руу дуудлага өгч, төвийн болон хэлтсийн даргад мэдэгдэнэ.
 - 2.5.2. Гал унтраах аврах анги ирэх хүртэл галын хор, бусад боломжийг ашиглан галыг унтраах арга хэмжээ авна.
 - 2.5.3. Цахилгааны гэмтлээс гал гарсан үед тоног төхөөрөмжийг хэлхээнээс салгах ба холбогдох бусад арга хэмжээг авна.
 - 2.5.4. Гал түймэр гарснаас нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах боломжгүй болсон тухайгаа НЦУТ-ийн Аюулгүй байдал чанарын менежерт мэдэгдэнэ.
 - 2.5.5. Төвийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу гал унтраах арга хэмжээ авч ажиллана.
- 2.6. Үйлдвэрлэлийн осол, ажилтан ажил үүргээ гүйцэтгэх чадамжгүй болох үед:
- 2.6.1. Урьдчилан мэдээлэхийн технологич инженер нь эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх чадамжгүй тохиолдолд яаралтай түргэн тусламж дуудаж, хэлтсийн даргад мэдэгдэнэ.
 - 2.6.2. Хэлтсийн дарга нислэгийн цаг агаарын мэдээгээр тасралтгүй хангах талаар дараагийн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана.
 - 2.6.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүй бол онцгой тохиолдлын үед дуудагдсан албан тушаалтан ажлын байранд саадгүй ирэх үүрэг хүлээнэ.

Гурав. Нислэгийн осол, зөрчлийг мэдээлэх, бүртгэх

- 3.1. Дээд байгууллагаас дор дурдсан мэдээллийг нислэгийн осол зөрчлийн мэдээлэлд хамруулдаг.
 - 3.1.1. Байгалийн гамшигт нэрвэгдсэнээс шалтгаалан нислэг, тээвэрлэлт, зорчигч үйлчилгээний үйл ажиллагаанд гарсан саатал, зөрчил;
 - 3.1.2. Нислэгийн осол, сүйрэл;
 - 3.1.3. Ажлын байр, үйлдвэрлэлийн объект, агаарын хөлөгт гарсан гал түймэр;



- 3.1.4. Үйлдвэрлэлийн аваар, ослын улмаас нислэг, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан;
- 3.1.5. Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан гэмт хэрэг, зөрчил;
- 3.1.6. Цаг агаарын мэдээний хангалтаас шалтгаалан гарсан саатал, осол;
- 3.2. Байгууламжийн доголдлын зөрчил гэж нисэхийн байгууламж болон түүний төхөөрөмжийн буруу ажиллагаатай холбоотой зөрчлийг хэлэх бөгөөд нислэгийн осол, зөрчил болсны дараа нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанд цаг уурын ажиглалтын автомат станц (AWS-310R)-д гарсан гэмтэлийг мэдэгдэнэ.
- 3.3. Түгээгдсэн мэдээллийн зөрчил гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан түгээгдсэн цаг агаарын ноцтой алдаатай, бүрэн бус, эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэлтэй холбоотой зөрчлийг хэлнэ. Нислэгийн осол зөрчил болсны дараа Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанд дараах түгээгдсэн мэдээллийн зөрчлийг мэдэгдэнэ.
 - 3.3.1. Урьдчилсан мэдээ (TAF, район, чиглэл, угталт)
- 3.4. Ээлжийн урьдчилан мэдээлэхийн инженер нь гэнэтийн осол, саатал, эвдрэл, сүйрэл, нислэгийн цаг агаарын мэдээний хангалтаас шалтгаалсан зөрчлийн талаарх мэдээллийг НЦУТ-ийн урьдчилан мэдээлэхийн технологич инженерт (71283039, 71287279, 71287419, 91287279) мэдээлнэ.
- 3.5. Байгууламжийн доголдлын зөрчлийг мэдээлэх хуудсыг Хавсралт 01, түгээгдсэн мэдээллийн зөрчлийг мэдээлэх хуудсыг Хавсралт 02-ын дагуу холбогдох хэлтсийн дарга хариуцан хөтөлж АБЧХХ-т хүргүүлнэ.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Нислэгийн осол, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.



**БАЙГУУЛАМЖИЙН ДОГОЛДЛЫН ЗӨРЧЛИЙГ
МЭДЭЭЛЭХ ХУУДАС**

№	Мэдээллийн утга	Тайлбар
1	Зөрчлийн огноо, цаг;	
2	Үйл явдлын товч тайлбар;	
3	Агаарын хөлгийн аялалын дугаар болон маяг;	
4	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;	
5	Агаарын хөлгөөр байршил, нислэгийн түвшин;	
6	Аэродромын нэр, ашигласан хөөрөх, буух зурвас;	
7	Нислэгт үзүүлсэн нөлөө;	
8	Цаг уурын ажиглалтын нөөц автомат станц (AWS-310)	

Мэдээлэл гаргасан: / гарын үсэг /
..... / овог, нэр /
..... / албан тушаал /
..... / он, сар, өдөр /

Мэдээлэл хүлээн авсан: / гарын үсэг /
..... / овог, нэр /
..... / албан тушаал /
..... / он, сар, өдөр /

ТҮГЭЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН ЗӨРЧЛИЙГ
МЭДЭЭЛЭХ ХУУДАС

№	Мэдээллийн утга	Тайлбар
1	Зөрчлийг илрүүлсэн огноо, цаг;	
2	Үйл явдлын товч тайлбар;	
3	Хэвлэл, газрын зураг, нислэгийн зураг, эсхүл бусад хэлбэрээр түгээгдсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдлийг таньж тогтоох дэлгэрэнгүй мэдээлэл;	
4	Зөрчилд хүргэсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл;	
5	Зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй;	

Мэдээлэл гаргасан: / гарын үсэг /
..... / овог, нэр /
..... / албан тушаал /
..... / он, сар, өдөр /

Мэдээлэл хүлээн авсан: / гарын үсэг /
..... / овог, нэр /
..... / албан тушаал /
..... / он, сар, өдөр /

Онцгой тохиолдолд мэдээлэл дамжуулах ерөнхий бүдүүвч

